



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

СЭЛЭНГЭ СУМЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: БУА-2026/01/НА-СА-ТТЗ

Цахим
хуудас:
www.audit.mn
Булган аймаг
2026 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас: 70342716 Цахим хаяг: Battsoqtd@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Намчинсүрэн
Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	Error! Bookmark not defined.
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
3.4.1 Мөнгөн хөрөнгө	Error! Bookmark not defined.
3.5.2 Авлага	Error! Bookmark not defined.
3.5.3 Урьдчилгаа	Error! Bookmark not defined.
3.5.4 Бараа материал	Error! Bookmark not defined.
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө	Error! Bookmark not defined.
3.5.6 Үндсэн хөрөнгө	Error! Bookmark not defined.
3.5.7 Өр төлбөр	Error! Bookmark not defined.
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..	Error! Bookmark not defined.
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.7.1 Завсрын аудитын талаар.....	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	7
5.3 Зөвлөмж.....	8
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	9

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026-03-25 № 345

танай _____ ны № _____ т

СЭЛЭНГЭ СУМЫН ЗАСАГ
ДАРГА А.ГАНБАГАНА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан, Засаг даргын харьяаны төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын асуудалтай холбоотой нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь 71.8 сая төгрөг байгаа нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 11.4 сая төгрөгөөр давсан ба материаллаг алдаа, зөрчил нь тархаагүй тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө. Үүнд:

- ЖДҮДС-аас олгосон зээлийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баримтжуулаагүй, зээлийн эргэн төлөх хугацаа хэтэрсэн ч дараагийн шатны арга хэмжээ авч ажиллаагүй;
- Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр бэлтгэсэн өвсний үлдэгдлийг жилийн эцсийн тооллогоор тоолж баримтжуулаагүй;
- Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрдэл дутуу;
- Дотоод хяналт хангалтгүйгээс харьяа төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил зэрэг нь НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.5, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.6, 20.2.9, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн

6326050654

15.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.4, 54 дүгээр зүйлийн 54.4.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2, 71.3 дахь заалт, УСНББОУС 1, 17-той нийцэхгүй, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийцлийн аудиттай холбоотой нийт 67.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн, ЗДТГ-ын санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа зориулалт бус зарцуулах, жил бүр дахин давтагдах шинжтэй буюу төлөвлөх боломжтой зардалд зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг.

Сумын ИТХ-ын 2025 оны тодотгосон төсөв батлах тухай 05/02 дугаар тогтоолоор татварын болон татварын бус нийт 979.2 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 976.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 99.7 хувиар биелүүлсэн байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Сэлэнгэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 7 хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 3,283.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 3,199.9 сая төгрөгийг зарцуулж 97.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Сэлэнгэ сумын ИТХ-ын VI/03 дугаар тогтоолоор сумын Засаг даргын үйл ажиллагааны “Сэлэнгийн сэргэлт” мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг 82 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй

баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31.
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	941,443.0	696,243.7
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,076,523.65	1,419,920.22
Нийт хөрөнгийн дүн	2,017,966.7	2,116,163.9
Нийт өр төлбөрийн дүн	18,075.1	19,912.2
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,999,891.6	2,096,251.7
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,017,966.7	2,116,163.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	3,226,396.5	3,155,114.9
Үйл ажиллагааны зардлын дүн	2,340,348.4	2,427,438.9
Үйл ажиллагааны үр дүн	886,048.1	727,675.9
Үйл ажиллагааны бус үр дүн	538,247.7	631,315.8
Үйл ажиллагааны нийт үр дүн	347,800.4	96,360.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,663,091.2	1,999,891.6
Тайлант оны үр дүн	336,800.4	96,360.1
Эцсийн үлдэгдэл	1,999,891.6	2,096,251.7
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,245,004.8	2,764,512.2
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,236,401.1	2,288,804.2
Үйл ажиллагааны ЦМГ	1,008,603.7	475,708.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(542,185.8)	(640,589.5)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(79,514.9)	(67,748.4)
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	386,903.0	232,629.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	213,618.4	600,521.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	600,521.4	367,891.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,261,869.2	2,865,291.6
Урсгал зардал	1,508,898.2	2,254,506.0
Хөрөнгийн зардал	752,971.0	610,785.5
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,261,869.2	2,865,291.6
Улсын төсвөөс санхүүжих	2,193,769.2	2,782,872.7
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	68,100.0	82,418.9

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 68.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс зөрчилд¹ 1.3 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 11.8 сая төгрөгийн 1 албан шаардлага, 55.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өгч ажиллаа.

Төсвийн шууд захирагчийн хүрээнд аудитаар нийт 1,121.0 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 26.09 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 69.81 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 1,049.2 сая төгрөгийн 10 зөвлөмж өгсөн байна.

3.1 Төлбөрийн акт

1.Сумын засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан Тэр бум мод үндэсний хөтөлбөрийн дагуу 12.0 сая төгрөгийн үр суулгацыг аж ахуй нэгж байгууллагад хуваарилан тариулсан боловч 115 ш суулгац дутсан санхүүгийн тайлангийн аудитын тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Нохой устгалын арга хэмжээний арга хэмжээнээс 765.0 мянган төгрөгийг зарцуулах захирамж гарсан ч тухайн ажлыг гүйцэтгэх гэрээ болон холбогдох анхан шатны баримт байхгүй байгаа нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Албан шаардлага

1. Байгаль хамгаалах сангаас хог ачих туслах ажилтны хөлс арга хэмжээнд 4.8, нохой устгал арга хэмжээнд 7.0 сая төгрөгийг төлөвлөн ИТХ-аар батлуулан зарцуулсан нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлагнал:

Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн иж бүрдлийг хангаж ирүүлэх, өмнөх оны тайлангийн үзүүлэлтийг илэрхийлээгүй тайланг үнэн зөв гэж баталгаажуулан ирүүлээгүй нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2025 оны 05 дугаар тушаалыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

2. Авлагын данс:

Илрүүлэлт:

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгосон 6.3 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй, сангаас зээл олгох эрх зүйн актгүй олгож байгаа нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллан авлагыг барагдуулах, ЖДҮДС-гаас зээл олгох эрх зүйн актыг боловсруулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах.

3. Нийт зардал:

Илрүүлэлт:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаартай тэнцэх төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд 11.8 сая төгрөгийг зарцуулаагүй. /ан амьтан, байгалийн ургамал ашигласны төлбөр/

Өгсөн зөвлөмж:

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хуульд заасны дагуу тухайн байгалийг нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөж, зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	6	26.23	2	1.34	1	11.8	3	13.09				
ЗДТГ	3	11.74	1	1.53			2	10.21				
Соёлын төв	1	1.95					1	1.95				
ИТХ	1	15.64			1	15.64						
ОНХС	2	97.6					2	97.6				
Ингэт дөл ОНӨАТҮГ	2	17.85					2	17.85				
ХХС	1	62.6					1	62.6				
Дүн	16	233.61	3	2.87	2	27.44	11	203.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ	1	42.0					1	42.0
Ингэт дөл ОНӨААТҮГ	1	105.0					1	105.0
ОНХС	1	752.9					1	752.9
Нийт дүн	3	899.9					3	899.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЗДТГ	2	54.73	1	0.56	1	54.17		
Нийт дүн	2	54.73	1	0.56	1	54.17		
Бүгд дүн	5	954.63	1	0.56	1	54.17	3	899.9